

МӨНГӨНИЙ ТОЙМ

2010 оны 2 дугаар улирал

1. ҮНЭ

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2010 оны 2 дугаар улиралд хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд өмнөх улиралтай харьцуулахад 3.7 хувь, оны эхнээс 11.4 хувь, өмнөх оны мөн үеэс 11.4 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд өмнөх улирлаас 6.9 хувь, оны эхнээс 16.2 хувь, өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар тус тус өссөн байна. Хэрэглээний үнийн индексийг ашиглан тооцсон *суурь инфляци* өмнөх улиралтай харьцуулахад 0.8 хувь, оны эхнээс 3.0 хувь, өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1

Хэрэглээний барааны үнийн индекс, Улаанбаатар хот

	Хувийн жин	2010-VI 2009-VI	2010-VI 2009-XII	2010-VI 2010-III
Хүнсний бараа, ундаа, ус	41.1	118.5	133.7	113.8
Согтууруулах ундаа, тамхи	2.3	103.9	101.9	100.6
Хувцас, бөс бараа, гутал	12.4	109.0	102.8	99.1
Орон сууц, ус, цахилгаан, түлш	13.4	105.3	103.7	104.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.3	102.6	101.2	101.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.6	106.6	101.7	101.3
Тээвэр	8.7	109.2	101.6	100.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.1	116.4	116.9	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.3	98.2	99.6	98.9
Боловсролын үйлчилгээ	4.2	109.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлч.	1.7	114.6	110.9	101.7
Бусад бараа үйлчилгээ	3.0	107.3	101.7	100.4
Ерөнхий индекс	100.0	112.6	116.2	106.9

Эх үүсвэр: Статистикийн сарын бюллетень, Үндэсний статистикийн хороо


Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2010 оны 2 дугаар улиралд 6.9 хувиар өссөн нь Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн бараа, үйлчилгээний үнэ 13.8 хувь, Орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 4.1 хувиар өссөнөөс голлон шалтгаалжээ.

Тайлант улиралд Хувцас, бөс бараа, гутал болон Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгээс бусад бүх бүлгийн бараа, үйлчилгээний үнэ өссөн байна. Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн бараа, үйлчилгээний үнэ бусад бүлгүүдийнхээс илүүтэйгээр өссөн бөгөөд уг бүлгийн үнийн өсөлтөд махны үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, тайлант улиралд хонины махны үнэ 44.9 хувь, үхрийн махных 37.8 хувь, адууны махных 32.5 хувиар тус тус өсчээ. Махны үнийн өсөлтийг 2009 оны 2 дугаар улиралтай харьцуулахад хонины махных 28.6, үхрийн махных 27.2, адууны махных 21.8 нэгж хувиар тус тус нэмэгдсэн байна. Харин сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ тайлант улиралд 15.7-18.1 хувиар буурчээ. Орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн

өсөлтөд халуун усны үнэ 50.0 хувь, цахилгааны үнэ 16.6 хувиар тус тус өссөнөөс шалтгаалав.

Зураг 1

Инфляци



2. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Мөнгөний нийлүүлэлт¹ өмнөх оны мөн үеийнхээс 44.5 хувь буюу 1084.4 тэрбум төгрөг, өмнөх улирлаас 18.5 хувь буюу 549.1 тэрбум төгрөгөөр өсч 3523.6 тэрбум төгрөгт хүрсэн. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт өнгөрсөн оны мөн үеийнхээс 49.3 нэгж хувь, өмнөх улирлаас 18.0 нэгж хувиар өссөн байна. Хадгаламж, зээлийн хоршоо дахь хадгаламж нь 2010 оны 6 дугаар сарын байдлаар банкуудын хадгаламжийн 1.5 хувийг эзэлж байв. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө өмнөх оны мөн үеэс 25.1 хувь буюу 89.7 тэрбум төгрөг, өмнөх улирлаас 16.4 хувь буюу 63.0 тэрбум төгрөгөөр өсч 447.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2.1 Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн

Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийг эх үүсвэр талаас нь авч үзвэл, бараг мөнгө 76.2 хувь (үүнд төгрөгийн хадгаламж 41.6 хувь, гадаад валютын хадгаламж 17.1 хувь, гадаад валютын харилцах 17.4 хувь), бага мөнгө буюу M1 мөнгө 23.8 хувь (үүнд банкнаас гадуурх мөнгө 9.9 хувь, төгрөгийн харилцах 13.9 хувь) тус тус эзэлж байв.

Хүснэгт 2

Мөнгөний үзүүлэлтийн жилийн өсөлт (жил бүрийн 2-р улирлын байдлаар, хувиар)

	М2 мөнгөнд эзлэх хувь*	2007	2008	2009	2010
М1 мөнгө	23.8%	52.8	24.4	-12.9	54.3
Банкнаас гадуурх мөнгө	9.9%	32.4	17.3	-7.8	22.9
Төгрөгийн харилцах	13.9%	83.8	32.2	-17.8	88.4
Бараг мөнгө	76.2%	35.1	28.1	-2.3	41.6
М2 мөнгө	100.0%	39.1	27.2	-4.9	44.5

*2010 оны 2-р улирлын байдлаар

Бараг мөнгө

Бараг мөнгө өмнөх оны мөн үеэс 41.6 хувь буюу 788.8 тэрбум төгрөг, өмнөх улирлаас 17.6 хувь буюу 402.2 тэрбум төгрөгөөр өсч 2683.7 тэрбум төгрөгт хүрэв. Бараг мөнгөний жилийн өсөлт нь өмнөх оны мөн үеэс 43.9 нэгж хувь, өмнөх улирлаас 17.7 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Нийт хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 33.5 хувь буюу 519.3 тэрбум төгрөг, өмнөх улирлаас 7.5 хувь буюу 145.1 тэрбум төгрөгөөр өсч 2070.0 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант улиралд төгрөгийн хадгаламж 6.7 хувь буюу 92.7 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 9.5 хувь буюу 52.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн. Гадаад валютын харилцах өмнөх оны мөн үетэй харьцуулахад 78.3 хувь буюу 269.5 тэрбум төгрөг, өмнөх улирлаас 72.1 хувь буюу 257.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.


Нийт хадгаламжийн 70.9 хувь нь төгрөгийнх, 29.1 хувь нь валютын хадгаламж байсан бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.5 нэгж хувиар өсчээ.

Бага мөнгө

Бага мөнгө (М1) өмнөх оны мөн үеэс 54.3 хувь буюу 295.5 тэрбум төгрөг, өмнөх улирлаас 21.2 хувь буюу 146.9 тэрбум төгрөгөөр өсч 839.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Бага мөнгөний жилийн өсөлтийн хурд 2009 оны мөн үеийнхээс 67.2 нэгж хувь, өмнөх улирлынхаас 18.8 нэгж хувиар өсчээ. Төгрөгийн харилцах өмнөх оны мөн үеэс 88.4 хувь буюу 230.4 тэрбум төгрөг, өмнөх улирлаас 23.2 хувь буюу 92.4 тэрбум төгрөгөөр өсч 491.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Банкнаас гадуурх мөнгө гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 78.0 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.4 нэгж хувиар бага байв. Мөн банкнаас гадуурх мөнгө М2-ийн харьцаа 9.9 хувь болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 1.7 нэгж хувиар бага байв.

Зураг 2

M1, M2, Бараг мөнгөний жилийн өөрчлөлт, хувиар



2.2 Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх оны мөн үеэс 11.9 хувь буюу 89.0 тэрбум төгрөг, өмнөх улирлаас 23.7 хувь буюу 160.8 тэрбум төгрөгөөр өсч 838.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Банкнаас гадуурх мөнгөний нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 нэгж хувь, банкуудын кассынх 1.7 нэгж хувиар тус тус өсч 41.6 хувь болон 11.6 хувь болсон бол Төв банкин дахь харилцах, хадгаламжийнх нь 5.5 нэгж хувиар буурч 46.8 хувьтай тэнцэж байв.

2.3 Гадаад, дотоод цэвэр актив

Гадаад цэвэр актив өмнөх оны мөн үеийнхээс 90.8 хувь буюу 857.0 тэрбум төгрөг, өмнөх улирлаас 24.9 хувь буюу 359.4 тэрбум төгрөгөөр өсч 1801.2 тэрбум төгрөг, дотоод цэвэр актив өмнөх оны мөн үеийнхээс 15.2 хувь буюу 227.4 тэрбум төгрөг, өмнөх улирлаас 12.4 хувь буюу 189.8 тэрбум төгрөгөөр өсч 1722.4 тэрбум төгрөгт хүрэв. Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл нийт мөнгөний 51.1 хувь нь гадаад цэвэр активт, 48.9 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна. Гадаад цэвэр активын M2 мөнгөнд эзлэх хувь өмнөх улирлаас 2.6 нэгж хувь, өмнөх оны мөн үеийнхээс 12.4 нэгж хувиар нэмэгджээ.


Гадаад валютын цэвэр албан нөөц

Гадаад валютын цэвэр албан нөөц өмнөх оны мөн үеэс 89.8 хувь буюу 581.8 сая ам.доллар, өмнөх улирлаас 11.1 хувь буюу 122.4 сая ам.доллараар өсч 1229.8 сая

ам.долларт хүрэв. Энэ нь импортын 23.4 долоо хоног буюу 5.9 сарын төлбөртэй дүйцэхүйц байна.

Зураг 3

Гадаад валютын цэвэр албан нөөц, сая ам.доллараар (жил бүрийн 2-р улирлын байдлаар)



Зээл

Хадгаламжийн байгууллагуудаас¹ олгосон зээл тайлант сарын эцэст 2882.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 12.6 хувь буюу 323.7 тэрбум төгрөг, өмнөх улирлаас 4.1 хувь буюу 114.1 тэрбум төгрөгөөр өсчээ. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон нийт зээл өнгөрсөн оны мөн үеийнхээс 9.7 хувь буюу 160.9 тэрбум төгрөгөөр өсч 1817.9 тэрбум төгрөг, иргэдэд олгосон зээл 18.7 хувь буюу 163.7 тэрбум төгрөгөөр өсч 1038.9 тэрбум төгрөг, бусад байгууллагад олгосон зээл 57.7 хувь буюу 3.8 тэрбум төгрөгөөр өсч 10.3 тэрбум төгрөгт тус тус хүрсэн бол улсын байгууллагуудад олгосон зээл өмнөх оны мөн үеийнхээс 22.8 хувь буюу 4.6 тэрбум төгрөгөөр буурч 15.6 тэрбум төгрөг болжээ. Хадгаламж, зээлийн хоршоодоос олгосон зээл банкуудын зээлийн 1.2 хувьтай тэнцэж байв. Зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.7 нэгж хувь, өмнөх улирлаас 9.0 нэгж хувиар өсчээ. Иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлт өнгөрсөн оны мөн үеийнхээс 33.8 нэгж хувиар нэмэгдсэн бол хувийн хэвшилд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлт 2009 оны мөн үеийнхээс 2.2 нэгж хувиар буурчээ.

Хүснэгт 3

¹ Хадгаламжийн байгууллагад банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага хамрагдана.

Зээлийн өрийн үлдэгдэл (жил бүрийн 2-р улирлын байдлаар, тэрбум төгрөг)


	2006	2007	2008	2009	2010
Нийт зээл	1,050.9	1,600.2	2,559.4	2,558.9	2,882.6
жилийн өөрчлөлт (%)	63.9	52.3	59.9	0.0	12.6
Төгрөгийн зээлийн хүү	24.2	21.0	21.7	23.5	19.7
жилийн өөрчлөлт	-8.5	-3.2	0.7	1.8	-3.8
Валютын зээлийн хүү	15.9	15.5	15.0	16.3	14.0
жилийн өөрчлөлт	-0.4	-0.4	-0.5	1.3	-2.3

Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 63.1 хувь нь хувийн хэвшил, 36.0 хувь нь иргэд, 0.5 хувь нь улсын байгууллага, 0.4 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 82.1 хувийг хэвийн зээл, 3.9 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 14.0 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин өмнөх улирлаас 1.6 нэгж хувиар буурч, харин өмнөх оны мөн үеэс 2.3 нэгж хувиар өсчээ.

Зураг 4

Зээлийн өрийн үлдэгдэл (жил бүрийн 2-р улирлын байдлаар)



Тайлант улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын үзүүлэлтүүдийг нэгтгэж санхүүгийн байгууллагуудын² мөнгөний тоймыг гаргасан болно. Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн өрийн үлдэгдэл нь 2010 оны 6 дугаар сарын байдлаар 51.9

² Санхүүгийн байгууллагад банк болон бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллагаас гадна банк бус санхүүгийн байгууллага орно.

тэрбум төгрөг байв. Нийт санхүүгийн байгууллагуудаас эдийн засагт оруулсан санхүүжилт нь 2934.5 тэрбум төгрөг байлаа.

Зээлийн хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 5.6 нэгж хувиар буурч, харин өмнөх улирлаас 0.8 нэгж хувиар өсч жилийн 10.87 хувьтай болов.

Банкуудын төгрөгийн болон гадаад валютын зээлийн жигнэсэн дундаж хүү³ өмнөх улирлаас 0.3 нэгж хувь, 0.9 нэгж хувиар тус тус буурч жилийн 19.7 хувь болон 14.0 хувь болжээ. Тайлант улиралд банкуудаас төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 6.0-24.8 хувь, валютаар олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 9.0-22.3 хувийн хооронд хэлбэлзэж байв.

3. МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2010 оны 6 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 134.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн бөгөөд үүний 5.3 хувь нь банк хооронд олгосон зээл, 6.7 хувь нь овернайт зээл, 22.0 хувь нь банк хоорондын хадгаламж, 31.2 хувь нь ТБҮЦ-ны хоёрдогч арилжаа, 34.9 хувь нь репо нөхцлөөр олгосон зээл байв. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 10.42 хувь байлаа. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 4.6 нэгж хувиар буурч, харин өмнөх улирлаас 3.2 нэгж хувиар өсчээ.

2010 оны 5 дугаар сарын 19-ны өдрөөс 2010 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал байлгах нөөцөд 102.9 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 60.2 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 136.7 тэрбум төгрөг, валютын нөөцөд 139.2 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

4. ВАЛЮТЫН ХАНШ

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2010 оны 2 дугаар улирлын эцэст 1368.65 төгрөг болж, өмнөх улирлаас 2 төгрөгөөр суларч, өмнөх оны мөн үеэс 67 төгрөгөөр чангарсан байна. 2010 оны 6 дугаар сард ам. долларын дундаж ханш 1380.33 төгрөг байв.

МОНГОЛБАНК

³ Зарласан хүү.